



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

「Байлдааны туг байрлуулж, туг залагч, тугч, туг хамгаалагчдыг томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 30.3, Цэргийн дүрмийн 7 дугаар бүлгийн 186, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын дотоод дүрмийн “Онцгой байдлын албаны туг, хүндэт дэвтэр, туг гардуулах, хадгалах, хамгаалах, анги, байгууллагыг нэрэмжит болгох тухай” хоёрдугаар хавсралтын 10-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын “Байлдааны туг”-ийг тус газрын нэгдүгээр давхарт “Тугны хүндэтгэлийн байр”-нд “Тугийн үнэмлэх”, “Хүндэт дэвтэр”-ийн хамт байрлуулсугай.

2. Нийслэлийн Онцгой байдлын газрын байлдааны туг залагч, тугч, туг хамгаалагчдыг хавсралтаар баталсугай.

3. Ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд байлдааны тугийг залахад цэргийн дүрэмт хувцас өмсөх, дүрмийн дагуу ёслолын хувцсыг өмсөж хэрэглэх, сахилга зохион байгуулалт, бэлтгэл хангуулан ажиллахыг Дэд дарга бөгөөд Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга (хошууч Б.Мягмардорж)-д даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2016 оны А/75 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т үүрэг болгосугай.

ДАРГА 
ХУРАНДАА  Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

1117155601
УХА0038 9072073

Нийслэлийн Онцгой байдлын газрын
даргын 2019 оны 03 дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар тушаалын хавсралт



**НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
БАЙЛДААНЫ ТУГ ЗАЛАГЧ, ТУГЧ, ТУГ ХАМГААЛАХ БҮРЭЛДЭХҮҮН**

Туг залагч:

1. Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Сургалт, гал түймэр унтраах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Ж.Алтанхуяг,

Тугч:

1. Санхүү эдийн засгийн хэлтсийн Нягтлан бодогч, дэслэгч Э.Эрдэнэбаатар,
2. Захиргааны удирдлагын хэлтсийн Судалгаа, дүн бүртгэл хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч Б.Баатар,

Туг хамгаалагч:

1. Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Хөдөлмөр хамгаалал, хорт хий утаанаас хамгаалах асуудал хариуцсан мэргэжилтэн, ахмад О.Мөнхбат,
2. Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Гал түймрийн улсын хяналт /жижүүр/-ын байцаагч, ахлах дэслэгч Ө.Ууганжаргал,
3. Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Сургалт, аврах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч Д.Батболд,
4. Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч Б.Анар.

---oOo---